

Түүх 7 : Естер хатан

Библийн эшлэл
[Естер 4:16]

Явж, Сусад байгаа бүх иудейчүүдийг цуглуулж, миний төлөө мацаг барьж, шөнө ч, өдөр ч гурван хоногийн турш бүү ид, бүү уу! Би болон миний шивэгчингүүд ч мөн ийнхүү мацаг барина. Хуулийн дагуу биш ч гэсэн би хаан дээр орно. Хэрэв би үхэх ёстой бол үхнэ.



Хааны хатан болох хүнийг сонгох тухай зар бүх нутаг даяар тархжээ.

Гоёж чимэглэсэн охид хааны ордон уруу ирцгээж байлаа.

Ордонд ажилладаг нэгэн Израиль гаралтай Мордехай гэдэг түшмэл байдаг байв. Түүнд Естер гэдэг үеэл охин дүү байжээ.

Естер нь маш үзэсгэлэнтэй нэгэн байжээ. Түүний аав ээж нь багад нь өнгөрсөн болхоор Мордехай түүнийг өөрийн охин шиг өсгөжээ. Естер ч бас хааны хатан сонгох үйл явцад оролцов.

Маш гоё хувцаслаж өөрсдийгөө чимэглэсэн охид хааны өмнө ирцгээв. Гэнэт хааны нүдэнд оч үсрэн гэрэлтэж эхлэв. Хаанд маш олон охидын дундаас Естер маш их таалагдаж түүнийг сонгожээ.

Тэгээд хаан Естерийн толгойд эрдэнийн шигтгээтэй титэм зүүлгэв.

Ингээд Естер хааны хатан болов. Үүний зэрэгцээ хаан Хаман гэдэг хүнийг улсын сайдаар томилжээ.

Ард түмэн бүгд шинэ сайд Хаманы өмнө өвдөг сөгдөн хүндлэв.

Гэтэл Хаманд огт сөгдөөгүй нэг хүн байлаа. Тэр хүн бол Естерийг өсгөсөн Мордехай байжээ.

Мордехай Бурханаас өөр хэний ч өмнө сөгдөн хүндлэхгүй гэхэд Хаман маш их уурлав.

Хаман, Мордехайг Бурханыг хүндэлдэг Израиль хүн гэдгийг нь мэдчихжээ.

Тэгээд тэр нэгэн хорон төлөвлөгөөг бодож олов.

Хаман, хаанд ингэж хэлэв. “Хаантан минь таны зарлигийг сахихгүй байгаа ард түмнийг хөнөөх хэрэгтэй.” гэж хэлэв.

Хаман хааны зарлигийг бүх нутаг даяар тараажээ.

“Манай улсад амьдардаг Израиль үндэстнийг дураараа алж тэдний хөрөнгийг авч болно.”

Үүнийг сонссон Израильчууд ихэд сандран, хоол ч идэлгүй Бурханы өмнө хувцасаа уран гунигтайгаар уйлцгаажээ.

Мордехай ч мөн адил хааны ордны хаалганы дэргэд суугаад уйлжээ.

Энэ мэдээг сонссон хатан Естер ихэд цочирджээ.



Хааны өмнө очихоос айсан Естер маш их санаа зовон, Мордехаи уруу өөрийн шивэгчинээ дахин явуулжээ. Мордехаи шивэгчинд ингэж хэлэв.

“Хааны хатан болсон шалтгаан нь ийм аюултай үеийн төлөө юм шүү дээ... гэж дамжуулаарай гэв..”

Шивэгчин Мордехаигийн хэлсэн бүх үгийг Естер хатанд дамжуулж хэлэв.

Естер хатан, Мордехаид шивэгчинээрээ дамжуулан хариу илгээв.

“Израильчуудад гурав хонгийн турш юу ч идэлгүй мацаг барин миний төлөө залбираарай гэж дамжуулаарай. Би ч бас юу ч идэлгүй залбирч, үхэх аюултай байсан ч хамаагүй хаанд очиж заавал хэлэх болно.”

Гурван хонгийн дараа Естер хатан, хааны өмнө очжээ. Хаан түүнийг хараад баярлав.

Хаан түүнд, “Естер ямар хэргээр ирэв? Чи хүсвэл хаант улсынхаа талыг өгөхөд ч бэлэн байна.” гэж хэлэв.

Харин Естер хаанд “Хаантан минь, би найр бэлдсэн тул, та Хамантай цуг ирнэ үү!”

Хатан өөрийг нь найранд урьсныг сонсоод Хаман бүр илүү бардамнажээ.

Хаан, Естериин бэлдсэн найранд сэтгэл нь хөдөлж, хатнаас хүслийг нь асуув.

Тэгэхэд Естер хаанд хандан, “Хаантан минь, би болон миний үндэстэн нэг билээ. Тиймээс миний ард түмний амийг авраач”

Эцэст нь Хаман Мордехаиг дүүжилж хөнөөх гэж бэлдсэн өнөөх дүүжлүүр дээрээ өөрөө дүүжлүүлэн амь эрсджээ.

Хаан олон жилийн өмнө хаан миний амийг аварсан хүн бол Мордехаи юм байна гэдгийг мэджээ. Тэгээд Мордехаиг сайдаар томилов. Мөн Естер хаанд дахин нэг хүслээ хэлжээ.

“Израиль хүмүүсийг алж болно гэсэн тушаалаа хүчингүй болгож өгөөч.” гэв.

Хаан, Естериин хүслийг ёсоор болгожээ. Ингээд Израильчуудаас нэг ч хүн үхээгүй юм.

Ийнхүү Естер хатан, Бурханд найдан залбирч, маш их зориг гарган хаантай уулзаж,

өөрийн үндэстнээ аварч чадсан юмсанжээ.

● Дараах библийн эшлэлийг дагаж бицээд, цээжлээрэй. (Естер 4:16)

Үхэх ёстой бол үхнэ.







